



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**АУДИТЫН СЭДЭВ: “АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2025 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬ ЗОХИОН  
БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН  
ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ”**



**ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ: УЛСЫН  
ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТИЙН 7.0  
ХУВИЙГ ҮР АШИГГҮЙ, 13.0 ХУВИЙГ  
АНХАН ШАТНЫ БАРИМТГҮЙ,  
ЗАРДЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН  
АНГИЛАЛ ЗӨРЧИН ЗАРЦУУЛЖ,  
ЗӨРЧЛИЙГ ДАВТАН ГАРГАСАН  
БАЙНА.**



## АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР.....	2
ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ .....	2
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ .....	3
БҮЛЭГ 1. СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНООС ТООЦОО СУДАЛГААНД ҮНДЭСЛЭХГҮЙГЭЭР 2,100.0 МЯНГАН ТӨГРӨГИЙГ ЗАРДАЛ ХООРОНД ШИЛЖҮҮЛЭН ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.....	5
БҮЛЭГ 2. ТӨСВӨӨС ОЛГОСОН САНХҮҮЖИЛТИЙН 7.0 ХУВЬ БҮЮУ 4,235.0 МЯНГАН ТӨГРӨГИЙГ ҮР АШИГГҮЙ ЗАРЦУУЛСАН БАЙНА.....	6
ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ : .....	10
ШИЙДВЭР:.....	10
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, ТАЙЛБАР:.....	11

### Товчилсон үгсийн тайлбар

ААН	Аж, ахуй нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
УИХ	Улсын Их Хурал
НББ	Нягтлан бодох бүртгэл
МТБ	Мэдээлэл технологийн баг

### Хүснэгт, дүрслэл, хавсралтын тайлбар

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Сонгууль зохион байгуулахтай холбоотой хуваарилсан санхүүжилт	6
Хүснэгт 1	Сонгуулийн хорооны сонгууль зохион байгуулахтай холбоотой төсвийн хуваарь, гүйцэтгэлийн тайлан	7-8
Хүснэгт 2	Сонгуулийн хорооны сонгууль зохион байгуулахтай холбоотой төсвийн гүйцэтгэлийн тайлан	8-9
Хавсралт 1	Сонгуулийн хорооны сонгууль зохион байгуулахтай холбоотой зардлын төсөвлөлт, гүйцэтгэл	12
Хавсралт 2	Улсын бүртгэлийн хэлтсийн сонгууль зохион байгуулахтай холбоотой зардлын төлөвлөлт, гүйцэтгэл	13

**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл**

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл”-д аудит хийж дүгнэлт гаргалаа.

**Аудитын зорилт**

Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилгын хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх;

**Аудитын хамарсан хүрээ**

Аудитад аймаг, сумдын Сонгуулийн хороо, Улсын бүртгэлийн хэлтсийг хамруулсан.

**Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитыг АДБОУС (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, тулгуур зарчим”, МУ-ын Ерөнхий аудиторын 2024 оны А/71 дүгээр тушаал “Нийцлийн аудитын заавар, аргачлал батлах тухай”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”д заасан арга зүйг ашиглан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, баримтад дурдсан мэдээлэлд судалгаа, шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

**Аудитын бүрэлдэхүүн, хугацаа**

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа хянан удирдаж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж стандартыг хангуулан, ахлах аудитор Д.Цэрэнханд, аудитор Н.Гэрэлмаа, Э.Сүнжидмаа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

### Хүндрэл бэрхшээл

Аудитын гүйцэтгэх үе шатны талбарын ажлыг 2025 оны 07 дугаар сарын 07-оос 09-ны өдөр хүртэл гүйцэтгэж, нэгтгэлийг 21-нээс 22-ны өдөр хийж, аудитын тайланг 25-ний өдөр баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

Аймаг, Бугат, Эрдэнэ сумдын Сонгуулийн хороо дансны үлдэгдлийг төвлөрүүлээгүй, сонгуулийн хорооны нэгтгэл тайланг 2 удаа гаргаж ирүүлсэн, аудитад баримт материалаа ирүүлсний дараа Сонгуулийн Ерөнхий хорооноос төсвийн хуваарийг дахин гаргаж хүргүүлсэн зэрэг асуудлууд нь аудитыг гүйцэтгэхэд хүндрэлтэй байлаа.

### Үндсэн мэдээлэл

Сонгуулийн ерөнхий хорооны 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 1/177 дугаар албан бичиг, 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 3/230 дугаар албан бичиг, 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 3/273 дугаар албан бичгээр аймаг, нийслэлийн нөхөн Сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтын талаар тайлбар ирүүлсэн байна.

Аймгийн сонгуулийн хорооны даргын 2025 оны 04 дүгээр захирамжаар Ажлын хэсгийг 6 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос нөхөн сонгууль зохион байгуулах зардалд Аймгийн сонгуулийн хороонд 62,727.2 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.


Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст нөхөн сонгуультай холбоотой 2,567.5 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар олгон, зарцуулсан байна.

Аймгийн Цагдаагийн газарт нөхөн сонгуультай холбоотой улсын төсвөөс санхүүжилт олгоогүй байна.

## БҮЛЭГ 1. СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНООС ЗАРДЛЫН ТООЦОО, ДҮНГ ҮНДЭСЛЭХГҮЙГЭЭР САНАЛ ХУРААЛТ ДУУССАНЫ ДАРАА ТӨСВИЙН ХУВААРЬТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН БАЙНА.

- 1.1 Аймгийн ИТХ-ын 2025 оны ээлжит нөхөн сонгуулийг Бугат сумын 5 дугаар, Эрдэнэ сумын 3 дугаар тойрогт зохион байгуулсан бөгөөд Аймгийн сонгуулийн хороог 12, сумын сонгуулийн хороодыг 28 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ.
- 1.2 Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны ээлжит нөхөн сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотойгоор улсын төсвөөс 62,272.0 мянган төгрөгийг аймагт хуваарилсан байна. Нийт санхүүжилтийн 27,540.8 мянган төгрөг буюу 44.2 хувийг сумдад, 34,731.2 мянган төгрөг буюу 55.8 хувийг Аймгийн сонгуулийн хороонд хуваарилжээ.
- 1.3 Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 3/273 дугаар албан бичгийн 1 дүгээр хавсралтаар аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтын тухай тайлбарыг ирүүлсэн байна.
- 1.4 Аймгийн сонгуулийн хороо ирүүлсэн зөвлөмж аргачлалын дагуу сумдын Сонгуулийн хороонд хүн амын тоо, газар нутгийн хэмжээнээс хамаарч төсвийг хуваарилжээ.

Дүрслэл №1: Хуваарилсан санхүүжилт (мянган төгрөг)



- 1.5 Нөхөн сонгуулийн санал хураалт дууссаны дараа буюу 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Сонгуулийн ерөнхий хорооноос урамшуулал, НДШ-ийн зардлын хэмнэлт 2,100.0 мянган төгрөгийг унааны зардалд зарцуулахаар Аймгийн сонгуулийн хорооны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулж, шинэчлэн ирүүлсэн байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс үзнэ үү)
- 1.6 Аймгийн сонгуулийн хорооноос төсөв хүрэлцэхгүй байгаа талаарх албан бичгийг Сонгуулийн ерөнхий хороонд албан бичгээр хүргүүлсэн гэх боловч аудитад хамруулаагүй.
- 1.7 Нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбоотой Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны 05 дугаар сарны 07-ны өдрийн А/82 тоот тушаалаар 2,567.5 мянган төгрөгийн санхүүжилтийг аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст олгожээ.

- 1.8 Улсын бүртгэлийн хэлтэст олгосон төсвөөс 1,687.5 мянган төгрөг буюу 65.7 хувийг урамшууллын зардалд, 800.0 мянган төгрөг буюу 31.2 хувийг албан томилолтын зардалд, 80.0 мянган төгрөг буюу 3.1 хувийг шуурхай багийн зардалд тус тус зарцуулсан байна. (Дэлгэрэнгүйг хавсралт-2-оос үзнэ үү)
- 1.9 Сонгуулийн үйл ажиллагаанд Улсын бүртгэлийн хэлтсийн 4 албан хаагчид ажилласан байна.
- 1.10 Улсын бүртгэлийн хэлтэст сонгууль зохион байгуулах санхүүжилтийг Ерөнхий газраас нь нэмэлт санхүүжилтийн дансаар олгож, тухай бүр аргачлал, зөвлөмжийг хүргүүлж, зарцуулалтад хяналт хэрэгжүүлж ажилласан байна.

**Аудитын илрүүлэлт:**

Нөхөн сонгуулийн санал хураалт дууссаны дараа 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Сонгуулийн ерөнхий хорооноос урамшуулал, НДШ-ын зардлын хэмнэлт 2,100.0 мянган төгрөгийг унааны зардалд зарцуулахаар төсвийн хуваарьт өөрчлөлт оруулсан байна.

**БҮЛЭГ 2. ТӨСВӨӨС ОЛГОСОН САНХҮҮЖИЛТИЙН 7.0 ХУВЬ БУЮУ 4,235.0 МЯНГАН ТӨГРӨГИЙГ ҮР АШИГГҮЙ ЗАРЦУУЛСАН БАЙНА.**

- 2.1 Аймгийн ИТХ-ын 2025 оны ээлжит нөхөн сонгуулийг зохион байгуулахаар улсын төсвөөс санхүүжүүлсэн 62,272.0 мянган төгрөгийн төсвийг бүрэн зарцуулсан байна.
- 2.2 Нийт төсвийн 44.2 хувийг сумдад, 55.8 хувийг Аймгийн сонгуулийн хороонд зарцуулсан байна.

**Хүснэгт1: Төсвийн хуваарь, гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)**

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Хэмнэлт, хэтрэлт
1	Маягт,хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	97.0	97.0	-
2	Сургалтын зардал	1,445.0	1,445.0	-
3	Бичиг хэрэг	800.0	800.0	-
4	Шуудан холбооны зардал	1,200.0	1,200.0	-
5	Унааны зардал	4,820.0	5,463.6	(643.6)
6	Санал авах байр,Төрийн далбаа бэлтгэх зардал	600.0	600.0	-
7	Сурталчилгааны зардал	1,400.0	1,400.0	-
8	Саналын хуудас,санал тоолох төхөөрөмж авах , буцаан хүргэх зардал	10,168.0	10,124.4	43.6
9	МТБ-ийн гишүүдийн холбоо, унааны зардал	750.0	750.0	-
10	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ	33,348.0	32,928.0	420.0
11	Томилолтын зардал	4,784.0	4,784.0	-
12	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардал	280.0	280.0	-
13	Шуурхай багийн зардал	2,580.0	2,400.0	180.0
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>62,272.0</b>	<b>62,272.0</b>	-

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Сонгуулийн хорооны төсвийн хуваарь, гүйцэтгэлийн тайлан

2.3 Аймгийн сонгуулийн хороо нь Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ-ийн зардлын төсвөөс 420.0 мянган төгрөгийг, шуурхай багийн зардлын төсвөөс 180.0 мянган төгрөгийг, саналын хуудас, санал тоолох төхөөрөмж хүргэх зардлын төсвөөс 43.6 мянган төгрөгийг, нийт 643.6 мянган төгрөгийг зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн, зөвшөөрөлгүйгээр унааны зардалд зарцуулсан байна. Энэ нь Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам"-ын 3.81 дахь заалтыг зөрчсөн байна.

**Хүснэгт 2: Төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)**

№	Зардлын нэр	Тайлагнаж ирүүлсэн гүйцэтгэл	Аудитлагдсан гүйцэтгэл	Зөрүү
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	97.0	97.0	-
2	Сургалтын зардал	1,445.0	1,445.0	-
3	Бичиг хэрэг	800.0	800.0	-
4	Шуудан холбооны зардал	1,200.0	1,200.0	-
5	Унааны зардал	5,463.6	5,333.8	129.8
6	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	600.0	600.0	-
7	Сурталчилгааны зардал	1,400.0	2,150.0	(750.0)
8	Саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, буцаан хүргэх зардал	10,124.4	10,244.0	(119.6)
9	МТБ-ийн гишүүдийн холбоо, унааны зардал	750.0	-	750.0
10	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ	32,928.0	32,928.0	-
11	Томилолтын зардал	4,784.0	4,790.0	(6.0)
12	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардал	280.0	278.6	1.4
13	Шуурхай багийн зардал	2,400.0	2,400.0	-
14	Татан төвлөрүүлсэн дүн	-	5.6	(5.6)
	<b>НИЙТ ДҮН</b>	62,272.0	62,272.0	-

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэлийн тайлан

2.4 Аймаг, сумдын сонгуулийн хороо нь зардлын эдийн засгийн ангилал зөрчин, мэдээлэл технологийн багийн гишүүдийн холбоо, унааны зардлаас 750.0 мянган төгрөгийг сурталчилгаанд буюу тараах материал худалдан авч зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1<sup>2</sup>, Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны А/17 дугаар тогтоолоор баталсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам"-ын 3.8<sup>3</sup> дахь заалтуудыг зөрчсөн байна.

<sup>1</sup> Сонгуулийн хороод нь хуваарилсан зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэхгүй бөгөөд шаардлагатай бол дээд шатны сонгуулийн байгууллагад албан ёсоор хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ.

<sup>2</sup> төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

<sup>3</sup> Сонгуулийн хороод нь хуваарилсан зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэхгүй бөгөөд шаардлагатай бол дээд шатны сонгуулийн байгууллагад албан ёсоор хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ.

- 2.5 Зардлын гүйцэтгэлээр саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, буцаан хүргэх зардлыг 119.6 мянган төгрөгөөр, сурталчилгааны зардлыг 750.0 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 6.0 мянган төгрөгөөр хуваарилсан төсвөөс тус тус дутуу зарцуулсан бөгөөд Бугат сумын Сонгуулийн хорооноос татан төвлөрүүлсэн 5.6 мянган төгрөгийг зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан байна.
- 2.6 Аймгийн сонгуулийн хороо нь сурталчилгааны зардалд 2,150.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч зарцуулалтын анхан шатны баримтгүй, бараа материалыг орлого авч, шаардахаар зарцуулсан баримтгүй байна. Нөхөн сонгуулийн санал хураалт дууссаны дараа буюу 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Тонхил сумын Алтансоёмбо багийн нутагт байрших Хөх-Ам булаг ХХК-ийн шатахуун түгээх станц руу 435.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч зарцуулалтын анхан шатны нотлох баримтгүй байна.
- 2.7 Аймгийн сонгуулийн хороо унааны зардлын төсвөөс 3,244.0 мянган төгрөгийн шатахуун авч зарцуулахдаа жолоочийн тооцооны хуудас хөтлөөгүй, тооцоо боддоггүй зөрчлийг давтан гаргасан байна.
- 2.8 Эрдэнэ сумын Сонгуулийн хороо унааны зардлын төсвөөс 597.2 мянган төгрөгийн шатахуун зарцуулахдаа жолоочийн тооцооны хуудас хөтөлсөн боловч спидометрийн заалт бичээгүй байна.
- 2.9 Сонгуулийн ерөнхий хорооноос 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 3/273 дугаар албан бичгээр Аймгийн сонгуулийн хорооны хоёр дахь санхүүжилтийн хуваарийн тайлбар болон төсвийг хавсралтаар ирүүлсэн байна.
- 2.9 Уг тайлбар зөвлөмжид Сонгуулийн саналын хайрцаг авчрах зардалд Сонгуулийн ерөнхий хорооноос 1 км-ын зардлыг 800 төгрөгөөр, 1 машинаар 2 удаа буюу Улаанбаатарт ирж очиход 4000 км-ээр тооцож, 3,200.0 мянган төгрөгийг хуваарилсан байхад Сонгуулийн саналын хайрцаг, саналын хуудас авчрахад иргэнтэй гэрээ байгуулан 7,000.0 мянган төгрөгийг зарцуулж, 3,800.0 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан байна. Энэ нь Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар " Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам"<sup>4</sup>-д заасантай нийцэхгүй байна.
- 2.10 Сонгууль зохион байгуулахтай холбоотой зардлын гүйцэтгэлд тавих Төрийн сангийн хяналт хангалтгүйгээс анхан шатны баримтын бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус, тооцоо бодохгүйгээр гүйлгээ хийсээр байна. Уг зөрчил өмнөх оны УИХ-ын болон аймаг, нийслэлийн орон нутгийн сонгуулийн зардлын гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрч, зөвлөмжүүдийг хүргүүлсэн.
- 2.11 Сонгуулийн ерөнхий хорооны хяналт сулаас дээрх зөрчлүүд давтан гарсаар байна. Энэ нь Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны А/17 дугаар тогтоолоор баталсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам"-ын 3.10<sup>5</sup> дахь заалттай нийцэхгүй байна.

---

<sup>4</sup> Сонгуулийн хороод хуваарилсан төсвийг зардлын эдийн засгийн ангиллын дагуу үр ашигтай хэмнэлттэй зарцуулна

<sup>5</sup> Сонгуулийн ерөнхий хороо нь Төрийн сан болон орон нутгийн аудитын байгууллагаар дамжуулан аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад, аймаг нийслэлийн сонгуулийн хороо нь сум

2.12 Улсын бүртгэлийн хэлтэс сонгууль зохион байгуулахтай холбоотой зардлыг баталсан төсвийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулсан байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Зардлын эдийн засгийн ангилал зөрчин, МТБ-ийн гишүүдийн холбоо, унааны зардлаас 750.0 мянган төгрөгийг сурталчилгаанд буюу тараах материал худалдан авахад зарцуулсан. (Аймгийн сонгуулийн хороо)
- Нөхөн сонгуулийн санал хураалт дууссаны дараа буюу 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Тонхил сумын Алтансоёмбо багийн нутагт байрших Хөх-Ам булаг ХХК-ийн шатахуун түгээх станц руу 435.0 мянган төгрөгийг зөвшөөрөлгүйгээр сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ-ийн зардлын төсвөөс шилжүүлсэн боловч зарцуулалтын анхан шатны нотлох баримтгүй байна. (Аймгийн сонгуулийн хороо)
- Сонгуулийн саналын хайрцаг авчрах зардалд Сонгуулийн ерөнхий хорооноос 1 км-ын зардлыг 800 төгрөгөөр, 1 машинаар 2 удаа буюу Улаанбаатарт ирж очиход 4000 км-ээр тооцож 3,200.0 мянган төгрөгийг хуваарилсан боловч хувь хүнтэй 7,000.0 мянган төгрөгөөр гэрээ байгуулан, 3,800.0 мянган төгрөгийг илүү шилжүүлж, үр ашиггүй зарцуулсан. (Аймгийн сонгуулийн хороо)
- Сурталчилгааны зардалд 2,150.0 мянган төгрөгийг анонс, тараах материал хийхэд зарцуулсан гэх боловч анхан шатны нотлох баримтгүй байна. (Аймгийн сонгуулийн хороо)
- Унааны зардлаас 3,244.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан гэх боловч жолоочийн тооцооны хуудас хөтлөөгүй, шатахууны тооцоог бодоогүй байна. (Аймгийн сонгуулийн хороо)

**Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:**

1. Сонгуулийн ерөнхий хорооноос 2,100.0 мянган төгрөгийн төсвийг зардлын тооцоо, нотлох баримтыг хянахгүйгээр зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн, төсвийн хуваарьт өөрчлөлт хийж, ирүүлсэн байна.
2. Аймгийн сонгуулийн хороог эс тооцвол сумдын Сонгуулийн хороо төсвийг зардлын эдийн засгийн ангиллын дагуу захиран зарцуулсан байна.
3. Сонгууль зохион байгуулахтай холбоотой зардлын гүйцэтгэлд тавих Төрийн сангийн хяналт хангалтгүйгээс анхан шатны баримтгүй ажил гүйлгээ хийсэн байна.
4. Нөхөн сонгуулийн төсвийн гүйцэтгэлд тавих Сонгуулийн ерөнхий хорооны хяналт сул байна.

**ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ: УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТИЙН 7.0 ХУВИЙГ ҮР АШИГГҮЙ, 13.0 ХУВИЙГ АНХАН ШАТНЫ БАРИМТГҮЙ, ЗАРДЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛАЛ ЗӨРЧИН ЗАРЦУУЛЖ, ЗӨРЧЛИЙГ ДАВТАН ГАРГАСАН БАЙНА.**

Дүгнэлтэд үндэслээд 12,479.0 мянган төгрөгийн 4 төрлийн зөрчил илэрснээс Сонгуулийн ерөнхий хороонд 2,100.0 мянган төгрөгийн 1, Аймгийн сонгуулийн хороонд 10,379.0 мянган төгрөгийн 3 зөрчил арилгах зөвлөмж хүргүүлж байна.

**ЗӨВЛӨМЖ:**

**СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНД**

- Аймгийн сонгуулийн хорооноос ирүүлсэн төсвийн тооцоолол, хэрэгцээ шаардлага судалгааг үндэслэж, албан бичгийг үндэслэн сонгууль зохион байгуулах зардлын төсөвт тодотгол хийж байх.

**АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНД**

- Сонгууль зохион байгуулахтай холбогдсон төсвийг баталсан хуваарийн дагуу зардлын эдийн ангиллыг дагуу арвилан хэмнэлттэй зарцуулж байгаад хяналт тавьж, зөрчил давтан гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцдог байх.
- Сонгуулийн зардлыг анхан шатны баримтад үндэслэн зарцуулалт хийж байх, сонгуулийн зардлын аудитад баримт материалыг бүрэн, гүйцэд ирүүлж байх.
- Сонгуулийн төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулах.

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

## ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, САНАЛД ӨГСӨН ХАРИУ ТАЙЛБАР

	ИРҮҮЛСЭН ТАЙЛБАР	ТАЙЛБАРТ ӨГСӨН ХАРИУ
1	Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн чиглэлийн дагуу сонгогчдын ирц хангах, техникийн саатал гаргахгүй байх тал дээр анхаарч хүн хүч, бензин шатахуун зарж ажилласан. Отор нүүдэл хийж яваа сонгогч малчдад хүрч мэдээлэл түгээх ажлаар Бугат сумын Тахийн тал, Тамачийн бэлчир зэрэг газруудаар явж байгаад шатахуун дууссан тул Тонхил сумын “Хөх ам булаг” ХХК-ийн Тахийн тал дахь салбараас 435.0 мянган төгрөгийн шатахуун зээл аван дараа нь төлбөрийг шилжүүлсэн.	Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам"-ын 4.1-д орлого, зарлагын гүйлгээнд холбогдох анхан шатны баримтыг зохих ёсоор бүрдүүлж хадгалах, мөн бүртгэлийг НББ-ийн тухай хуульд заасны дагуу хөтөлнө гэж заасан. Уг зардлыг сонгуулийн ажилтны урамшуулал НДШ-ийн зардлаас зөвшөөрөл авахгүйгээр шилжүүлсэн ба шатахууны зарцуулалтын анхан шатны баримтгүй тул төлбөрийн акт тогтоосон. Зөрчилтэй асуудлын бүртгэлтэй танилцаад ирүүлсэн 2025 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 20 дугаар албан бичигт нотлох баримтыг ирүүлсэн тул төлбөрийн актыг зөвлөмж болгосон.
2	Сонгуулийг үр дүнтэй болгохын тулд тодорхой зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллаж төсөвлөсөн зардал хүрэхгүй байсан тул урамшууллын зардлаас 2,100.0 мянган төгрөгийг унааны зардалд шилжүүлсэн.	Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлсэн албан бичиг, нотлох баримтаа ирүүлээгүй тул нэгдсэн тайланд тусгуулах саналыг хэвээр үлдээсэн.
3	Сонгуулийн Ерөнхий хорооноос санал тоолох төхөөрөмж, саналын хуудсыг улсын бүртгэлийн тоног төхөөрөмжтэй хамт хамт цагдаа, тагнуул, улсын бүртгэл, аймгийн сонгуулийн хорооны болон мэдээлэл технологийн багийн 10 орчим хүнтэй авч яван буцааж хүргэдэг хуультай. Өмнөх сонгуулиудаар ийм жишгээр үүнээс ч илүү зардал гаргаж автобуснуудтай гэрээ байгуулан ажиллаж байсан баримт бий. Төхөөрөмж саналын хуудас, холбогдох албаны хүмүүсийг тээвэрлэхэд 1 км-ийг 800 төгрөгөөр тооцно гэсэн заалт журам байхгүй.	Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам"-ын 3.6-д "Сонгуулийн хороод хуваарилсан төсвийг зардлын эдийн засгийн ангиллын дагуу үр ашигтай хэмнэлттэй зарцуулна" гэж заасан. Танай ирүүлсэн тайлбарт өмнөх сонгуулийн жишгээр тооцож 45 хүний суудалтай автобус түрээсэлсэн гэж дурджээ. Өмнөх сонгууль 18 сумын 83 багт зохион байгуулагдаж байсан бол нөхөн сонгууль нь 2 сумын 2 багт зохион байгуулагдсанаараа онцлогтой. Иймд Сонгуулийн хорооноос ирүүлсэн нотлох баримтыг үндэслэн төлбөрийн актыг зөвлөмж болгосон.